

Т.Дорждагва

Философийн тэнхимийн багш,
доктор/PhD/, профессор

**“СОЁЛ”, “УРАН САЙХНЫ СОЁЛ”, “УРЛАГ”
ХЭМЭЭХ ОЙЛГОЛТУУДЫН ТУХАЙ**

Түлхүүр үг:

- Соёл
- Урлаг
- Уран сайхны соёл
- Соёлын тухай тодорхойлолт
- Уран сайхны соёлын бүрэлдэхүүн хэсэг
- Урлаг, уран сайхны соёлын шүтэлцээ, ялгаа

Товч утга: Зохиогч энэхүү өгүүлэлдээ “соёл”, “уран сайхны соёл”, “урлаг” хэмээх ойлголтуудыг ялгаж тодотгох зорилго тавьсан бөгөөд гадаад, дотоодын судлаачдын бүтээлийг үзэж, харьцуулан шинжлээд дээр дурдсан асуудлаар өөрийн баримтлалаа илэрхийлсэн болно. Энд соёлын тухай цөөнгүй тооны тодорхойлолтыг толилуулж үлгэр болголоо. Цаашид соёлын тухай тодорхойлолтын тоо ихэд өсөх хандлагатайг тэмдэглээд, соёлын тухай бодитой тайлбар байх нь зүйтэй хэмээн үзэж өөрийн тайлбарыг томъёолж орууллаа. Уран сайхны соёлын бүтцийн талаар зарим судлаачидтай санал зөрөөтэй байгаа тул өөрийн үзлийг илэрхийлсэн болно.

Оршил

Манайд эдүгээ ч гэсэн “соёл”, “урлаг” хэмээх ойлголтуудыг адилтган ухаарах явдал ердийн ухамсрын түвшинд төдийгүй, “боловсролтой” зарим хүмүүсийн дунд оршиж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж, өдөр тутмын яриа хөөрөлдөөнөөс мэдрэгдэж байдаг юм. Ийм учраас бид өмнө дурьдсан хоёр ойлголтоос гадна “уран сайхны соёл” гэдэг ойлголтыг оролцуулан, эдгээр гурван ойлголтын харилцаа холбоог тодруулан гаргах оролдлого хийхийг зорьсон болно.

1. “Соёл” хэмээх ойлголтын талаар

Хүн хийгээд нийгэмд илрэх аливаа зүйлийг байгалийн, эсвэл бурхан тэнгэрийн үүдэлтэй гэх төсөөлөл өөрчлөгдөж, хүмүүний өөрийнх нь үйл ажиллагаагаар шалтгаацлан буй болдог өөр юмс, өөрөөр хэлбэл өөрийнх нь бүтээсэн ертөнц бас байдгийг, тэрчлэн хүн өөрөөсөө хамааралтай байж, хүрээлэн буй бодит байдлыг

өөрчлөх тодорхой чадвартай болохоо ухаарснаар хүн төрөлхтөн соёлын ертөнцийг анх олж харсан бололтой. “Соёл” хэмээх үг нь латин хэлний “cultura” буюу “газрыг эдлэх”, “ургуулах”, “газар тариалан эрхлэх” гэсэн утгатай үгнээс үүдэлтэй болох талаар сурах бичиг, гарын авлага, лавлах материалуудад нэгэнт хангалттай тусгагджээ. Харин энэ нь хятадын “жэнь”, энэтхэгийн “жарма”, грекийн “пайдейя”-тэй утга дүйдэг бөгөөд тэрчлэн монгол хэлэнд “соёо”, “соёол”, “соёолох” буюу ургамлын сүслэх, ногоо соёолох утга буйг хэн бүхэн мэдэх билээ. Тэгэхлээр түүнийг этимологийн буюу үгийн гарваль зүйн үүднээс сонирхон үзэж, судлууштай зүйл юм.

Улмаар “соёл” хэмээх ойлголтын тухай төсөөлөл үе үеийн сэтгэгчдийн бүтээлд тусгагдан улам боловсронгуй болсоор түүнийг тодорхойлох шатанд нэгэнт хүрч иржээ. Цаашид энэхүү ойлголт нь мэдлэгийн олон салбарын, нэн ялангуяа философи сэтгэлгээний халамж анхааралд бойжсоор эдүгээ соёлын философи болон соёл судлал хэмээх биеэ даасан тусгай шинжлэх ухааны судлагдахуун болоод байна.

Соёлын тухай анхны тодорхойлолтыг английн угсаатны зүйч Эдуард Тайлор(1832-1917) анх 1871 онд өгсөн ба тэрээр соёлыг нийгмийн гишүүн болох хүнд байх мэдлэг, урлаг, ёс суртахуун, эрх, зан заншил болон бусад онцлогуудын нийлбэр цогц гэж томъёолсныг П.С.Гуревич гуай “Соёлын философи”-доо тэмдэглэсэн байдаг /2. 20/. Гэтэл америкийн соёл судлаач Альфред Кребер, Клайд Клакхон нар “Соёл: Үзэл баримтлал болон тодорхойлолтын шүүмжлэлт тойм” хэмээх хамтын бүтээлдээ 1871-1919 онд соёлын тухай 7, 1920-1950 онд 157 тодорхойлолтыг судлаачид гаргасан болохыг тэмдэглэсэн юм /6/. Мөн сүүлийн үеийн зарим ном бүтээлд энэхүү тодорхойлолтын тоо нилээд өссөнийг бас тэмдэглэжээ. Тухайлбал, судлаач Л.Е.Кертман 400 гаруй тодорхойлолтыг тоолсон /11. 12/ бол К.М.Хоруженко өөрийн бичсэн соёл судлалын нэвтэрхий толь бичигтээ соёлын тухай тодорхойлолт хагас мянгад /14. 355/ хүрснийг тэмдэглэсэн байна.

Соёлын тухай тодорхойлолтын тоо ийнхүү өссөөр байдаг нь хэд хэдэн бодит шалтгаантай холбоотой нь ажиглагддаг. Юуны түрүүнд соёлын үзэгдлийг авч үздэг мэдлэгийн олон төрлүүд түүнийг тал бүрээс нь өөр өөрсдийн цонхоор харж, тус бүрийнхээ судалгааны объект, судлагдхуун, судалгааны аргын онцлогын үүднээс томъёолон тодорхойлох оролдлогыг хийдэг байна. Нөгөө талаар судлаач бүхэн өөрийн харъяалагдах шинжлэх ухааны нэр хүндийг бодож, өвөрмөгц тодорхойлолт өгөх гэсэн эрмэлзлэлдээ хөтлөгдөн субъектив хандлагад ордог тал байдаг бололтой. Гэвч соёл гэдэг феномен өөрөө олон тал онцлогтойн дээр, өргөн цар хүрээтэй, нарийн төвөгтэй үзэгдэл байдаг нь түүнийг авч үзэх хэд хэдэн хандлагыг буй болгож, соёлын тухай олон загвар, хэдэн зуугаар тоологдох тодорхойлолтыг төрүүлэх гол шалтгаан болсон байна.

Соёл хэмээх үзэгдлийг тодорхойлох оролдлого энэ мэтээр багагүй чармайлт шаардаж байгааг бид анзаарч байна. Цаашид ч уг тодорхойлолтын тоо хумигдахаасаа нэмэгдэх нь илүү магадлалтай. Түүний тоог цаашид өсгөөд байх нь ялангуяа сургалтын практикт төдийлөн чухал биш юм, харин соёлын тухай үндэслэл сайтай, оновчтой тайлбар өгөх нь илүү ач холбогдолтой ч байж мэдэх билээ. Тэгэхлээр юуны түрүүнд үе үеийн гарамгай сэтгэгчид, нэрт эрдэмтэд, зарим судлаачдийн өгсөн тодорхойлолтыг орсын эрдэмтэн В.И.Полищук 1999 онд хэвлүүлсэн "Соёл судлал" гарын авлагадаа оруулснаар /10. 16-19/ энд толилуулъя. Соёлыг:

-амьдрал нь протоплазмын оршин байх арга юм гэдгийн адил хүн төрөлхтний оршин байх арга юм (Германы философийн толь бичиг);

-материаллаг юмс, гадаад зан үйл, бэлэгдлийн зан үйл буюу нийгмийн зохион байгуулалт гэхчлэн хүний бүтээсэн бүх юм (Л.Бернард);

-өөрийг нь хүрээлэн буй байгалийн орчин болон эдийн засгийн хэрэгцээндээ хүн дасан зохицох өвөрмөц арга, амьдралын ерөнхий дүр зураг (К.Даусон);

-нийгмийн хүмүүний бүхий л үйл ажиллагаа (А.Кребер);

-өөр хоорондоо харилцан үйлчлэлцэж, зан үйлийг харилцан нөхцөлдүүлэх хоёр ба түүнээс олон индивидумын ухамсарт буюу ухамсарт бус үйл ажиллагааны үр дүнд бүтээгдсэн буюу шинэчлэгдсэн бүх юм (П.Сорокин);

-нийтлэг буюу овог аймаг мөрдвөл зохих амьдарлын арга (К.Уислер) гэж хүн судлалын үүднээс өгсөн тодорхойлолтууд нь харваас маш өргөн цар хүрээтэй бөгөөд агуулгаараа нийгмийн түүхэн дэх бүх амьдралтай давхцах байдаар ойлгогдож байгааг анзаарах буй заа. Тэгвэл социологийн хандлагын үүднээс үзвэл соёлыг:

-нийгмийн холбоог зохион байгуулж, нийгмийн туршлагын ерөнхий тайлбарлалыг боломжтой болгодог, бат тогтвортой үзэл бишрэл, үнэлэмж болон зан үйлийн хэм хэмжээ (У.Бекет);

-уламжилагдах бүтээл, юмс, техникийн үйл явц, үзэл санаа, зан заншил болон үнэлэмж (В.Малиновский);

-хэл, үзэл бишрэл, гоо сайханы таашаал, мэдлэг, мэргэжлийн ур чадвар болон аливаа төрлийн зан заншил (А.Радклифф-Браун);

-сэтгэлгээний ерөнхий бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн арга (К.Юнг) гэх жишээтэй. Харин философи хандлагын үүднээс тодорхойлсон зарим тодорхойлолтыг дараах цөөн тодорхойлолтоор жишээ болгоё. Тухайлбал энд соёлыг:

-хаалттай нэгдлээс хөгжингүй олон янз байдлаар дамжин хөгжингүй нэгдэлд хүрэх зам (Г.Зиммель);

-нийгэмшлийн үйл явцын тусламжтайгаар нийгэмд дамжигдах харьцангуй тогтмол материаллаг бус агуулга (Г.Беккер);

-түүхэнд хадаглагдаж үлдээд нийгмийн ухамсарт орох, дотоод ухамсарт үндэслэгдсэн бэлгэдлийн илэрхийлэл (Д.Режин) гэсэн байна.

Түүнчлэн 1970-1980-аад онуудад М.М.Розенталь, хожим нь И.Т.Фроловын редакцитайгаар ЗХУ-д олон удаа хэвлэгдсэн "Философийн толь" хамтын бүтээлд соёл бол "Хүн төрөлхтөн нийгэм-түүхэн практикийнхаа явцад бүтээсэн бөгөөд бүтээж байдаг, мөн нийгмийн хөгжлийн түүхэн ёсоор хүрсэн түвшинг тодорхойлж байдаг материаллаг ба оюуны үнэлэмжүүдийн цогц юм" /12.173/ гэж, мөн 1983 онд Москвад хэвлэгдсэн "Философийн нэвтэрхий толь бичиг"-т А.И.Арнольдов, М.А.Батунский, В.М.Межуев нар хамтарч бичсэн өгүүлэлдээ соёл бол "Хүмүүний амьдал, үйл ажиллагааг хөгжүүлж, зохион байгуулах арга, материаллаг ба оюуны хөдөлмөрийн бүтээгдэхүүн, нийгмийн янз бүрийн хэм хэмжээ болон байгуулалтын тогтолцоо, оюуны үнэлэмж, хүмүүсээс байгальтай, өөр хоорондоо болон өөртэйгөө харьцах харилцааны цогц зэрэгт илрэх арга юм" /13. 292/ хэмээн томъёолсон байдаг. Бас 2001 онд хэвлэгдсэн олон орны философичдын хамтын бүтээл болох "Даян дэлхийн нэвтэрхий толь. Философи" гэдэг томоохон хэмжээний ажилд оросын философич В.С.Степин соёл бол "Хүний үйл ажиллагаа, зан үйл, хамаарлын биологиос дээгүүрх бөгөөд нийгмийн амьдрал, үндсэн бүх илрэлүүдээрээ нөхөн үйлдвэрлэгдэж, өөрчлөгдөх нөхцөл болдог, түүхэн хөгжил бүхий хөтөлбөрүүдийн тогтолцоо мөн" /1. 524/ гэж тодорхойлсон байна.

Өнөөдөр соёл судлалын чиглэлээр бичигдсэн сурах бичиг, гарын авлага, лавлах нотлох материал, толь бичгүүд, суралцагчдын мэдлэгийг хянаж шалгах хэрэглэгдэхүүн, унших бичиг, уг сурвалжуудыг үйл олноор нь хэвлэн нийтэлж байна. Түүний нэг болох К.М.Хоруженкогийн "Соёл судлал. Нэвтэрхий толь бичиг" бүтээлд соёлыг "Хүмүүс өөрсдийн амьдралын үйл ажиллагааг зохион байгуулахдаа ашигладаг, нэг үеэс нөгөө үед дамжуулан олж авдаг, нийгмийн учир холбогдол бүхий бэлгэдэл, үзэл санаа, үнэлэмж, зан заншил, бишрэл, уламжлал, хэм хэмжээ болон зан үйлийн дүрмүүдийн тодорхой нийлбэр цогц" /14. 228-229/ гэж болгоожээ.

Манай оронд анх удаа 1998 онд хэвлэгдсэн "Соёл судлалын үндэс" гарын авлагад "Соёл бол хүмүүний хүмүүнлэг чанар илрэн хэрэгжих түүхэн тасралтгүй үйл явц, түүний үр дүн мөн" /3. 65/ гэсэн бол доктор, профессор Ц.Гомбосүрэн өөрийн диссертацидаа "Соёл бол байгалийн зүйлийг нийгмийн зүйл болгодог, мөн нэгэнт бий болгосон нийгмийн зүйлийг улам бүр боловсронгуй болгодог зохистой арга мөн" /16. 23/ хэмээн тус тус томъёолон тодорхойлсон билээ.

Энэ бүгдээс үзвэл соёл нь чухамхүү хүнтэй л холбоотой бөгөөд бусдаас хүний ялгагдах чанарыг илэрхийлэхтэй чухам холбоотой болох нь тодорхой байна. Иймээс соёлын тухай авч ярих

ахул заавалчгүй хүнтэй, түүний үүсэл, хөгжил, мөн чанартай холбож авч үзэхээс аргагүйд хүрэх ба хүнээс гадуур биеэ даасан тусгаар соёлын тухай ярих боломжгүй нь харагдаж байна. Энэ бол соёлыг авч үзэх антропологийн зарчим. Өөрөөр хэлбэл энэ тал дээрээ үеийн сэтгэгчид, янз бүрийн үзэл баримтлал бүхий эрдэмтэн мэргэд, судлаачид нэгдсэн гэж үзэх үндэстэй юм. Иймд дээрх тодорхойлолтууд нь дурьдагдан буй үзэгдлийн тухай зохих тодорхой мэдлэг олж авахад болон цаашид түүнийг гүнзгийрүүлэн судлаж томъёолоход ихээхэн ач холбогдолтой болох нь гарцаагүй.

Соёлын тухай мэдлэг үндсэндээ философи сэтгэлгээний түүхэнд боловсорч ирсэн байдаг. Гэтэл эдүгээ хүн судлал, археологи (хуучны судлал), түүх, шашин судлал, хэл шинжлэл, социологи, урлаг судлал, угсаатны зүй, улс төр судлал болон бусад олон шинжлэх ухаан соёлын үзэгдлийг шимтэн сонирхож, түүгээр ч барахгүй соёлын философи, соёлын хүн судлал, соёлын социологи, соёлын сэтгэл зүй болон соёл судлалын бусад салбар ухаанууд "соёл" хэмээх феноменийг тал бүрээс нь авч үзэж, түүний тухай арвин баялаг мэдлэгийн санг буй болголоо. Гэвч "соёл" хэмээх энэ өргөн ойлголтыг шинж тэмдгийн нийлбэр цогцыг ялган үзэх буюу төрөлжүүлэх үндсэн дээр гаргаж авсан аль нэг "өвч тодорхойлолтоор илэрхийлэх" нь төвөгтэй байгаа юм. Иймд соёлын тухай аливаа тодорхойлолт нь түүнийг авч үзэх аль нэг зорилгоос хамаарсан, түүний тухай зөвхөн тайлбарлал л байдаг гэж хэлмээр санагдана. Тухайлбал, соёл нь хүн өөрийн төрөлх уг чанараа бүтээх үйл явц, хүн дэх "хүний" хэмжүүр бөгөөд философийн үүднээс үзвэл соёл нь бүхэлдээ хүн өөрийгөө олж харах ертөнц мөн гэж хэлж болно, нөгөө талаар соёл нь хүнээс ертөнцөд хандах, түүнд оршин байх, түүнийг зохистойгоор өөрчлөх арга гэж тайлбарлах саналтай байна.

Харин тухайн судлаач соёлын асуудлыг бүхэлд нь хамаарч авч үзэх бололцоогүйн улмаас түүний аль нэг тусгаар талд анхаарлаа түлхүү хандуулдаг байна. Жишээлбэл, нэг хэсэг нь соёлыг уламжлалтай холбож, нийгмийн өв гэж үзэж байхад, нөгөө хэсэг нь соёлын хэм хэмжээлэг шинжийг онцолж, тухайн нийгмийн аж төрөх ёсыг тодорхойлох дүрмүүдийн цогц хэмээн тайлбарлаж, гурав дахь хэсэг нь байгаль, нийгмийн орчны тодорхой нөхцөлд хүн дасан зохицох явдлыг нөхцөлдүүлэх соёлын зохицуулгын функцийг тэргүүн зэрэгт тавих жишээтэй.

Харилцан бие биенийгээ нөхөн гүйцээж, нягт холбоотой хөгжиж байгаа соёл судлал, соёлын хүн судлал гэсэн шинжлэх ухааны шинэвтэр салбарууд баруунд үүсэн буй болсон нь нийгмийн амьдралын бүхий л талд соёл идэвхитэй үйлчилж байдгийн нэг нотолгоо юм. Нийгэм дэх соёлын функцийг бодитойгоор ухамсарласан нь эдийн засаг, улс төрийн хүчин зүйлийн гүйцэтгэх үүргийг хэт туйлчлэх үзэлд няцаалт өгчээ. Эдийн засаг, улс төр зэрэг нийгмийн амьдралын үзэгдлүүд нь соёлын онцлогоор үндсэндээ

тодорхойлогддог байна. Нэг л хэлбэрийн эдийн засаг, эсвэл улс төр боловч, өөр өөр хэв маягийн соёл бүхий нийгэмд янз бүрээр хэрэгжиж, түүгээр ч барахгүй чухам соёлын онцлог л тухайн эдийн засаг, улс төрийг төрүүлдэг ажээ. Тодорхой нэг нийгмээс бусад нийгмийн амьдралын зохион байгуулалтын аль нэг хэлбэрийг зээлдэх механизм ч соёлын шинж чанараар ихээхэн тодорхойлогддог байна.

Энэ бүхнээс үзвэл “соёл” гэдэг ойлголтыг дан ганц “урлаг”-тай адилтгах бололцоогүй болох нь илэрхий харагдаж байгаа болов уу.

2. Уран сайхны соёлын талаар

Судлаач Ю.А.Лукин /5.22/ нийгмээс бүтээсэн үнэлэмжүүдийн нийлбэр цогц, тэрчлэн тэдгээрийг нийгэм болон тусгаар хүмүүс бүтээх, дэлгэрүүлэх, хүртэж эзэмших үйл явц өөрөө уран сайхны соёл мөн гэж тодорхойлсон бол В.В.Журавлев уран сайхны соёлыг урлагийн үйлдвэрлэл, түүнийг дэлгэрүүлэх, ухуулж сурталчилах, хүртэх, ойлгох, урлагаар цэнгэх соёл, гоо сайхны хүмүүжлийн соёл гэж ойлгосон байна /5. 24/. А.А.Радугиний редакцитай хэвлэгдсэн “Соёл судлалын нэвтэрхий толь”-д: “Уран сайхны соёл гэдэг бол ертөнцийг гоо сайхны хувьд эзэмших, практик болон өөр туршлагыг уран сайхнаар, ахуй амьдралын болон үйлдвэрлэлийн сэтгэл хөдлөлийг гоо сайхнаар нөхөн гүйцээх, хүнийг сайхнаар төгөлдөржүүлэх нь бүх субъектийн үйл ажиллагааны агуулга ба зорилго болсон соёлын мэргэжсэн хүрээ юм” /17. 421/, К.М.Хоруженкогийн толинд “Уран сайхны соёл нь урлагийн бүтээл болон гоо сайхны үнэлэмж бүхий материаллаг зүйл, юмсыг бүтээж, дэлгэрүүлж, эзэмшиж байдаг оюуны практик үйл ажиллагааны үзэгдэл болон үйл явцын нийлбэр цогц” /14. 530/ гэсэн утгаар тус тус томъёолсон байна.

Эдгээр болон бусад тодорхойлолтоос үзэхэд уран сайхны соёл нь урлагтай зайлшгүй холбоотой юм. Гэхдээ уран сайхны соёлыг урлагаас ялгаж ойлгох ёстой. Уран сайхны соёл нь урлагаас хавьгүй өргөн ойлголт бөгөөд тэр нь соёл гэдэг утгаараа урлагийн бүтээлийг буй болгох болон түүнийг хүртэх арга, урлагийн бүтээлийг хадгалах, дэлгэрүүлэх, олшруулан хувилах, хэрэглэх, судлах, түүнд нөлөөлөх үйл ажиллагааны арга чадвар. Энэ дашрамд бид орос хэлний “способ”-ийг арга, “способность”-ийг авъяас, чадвар гэхчлэн утгын хувьд холдуулан тасчиж орчуулан, арга чаргатай байваас чадвартай хийгээд авъяастай байх санаа, боломжийг бүрхэгдүүлэн гэж ирснийг тэмдэглэх нь зүйтэй юм. Харин урлаг нь урлан бүтээх үйл ажиллагааны бүтээгдэхүүн болно. Хэрэв урлаг нь бэлэн уран бүтээл бол, уран сайхны соёл нь тэдгээрт шингэсэн мэдлэг, үнэлэмж, хэм хэмжээ, үлгэр дууриал болон хүн өөртөө эдгээр үнэлэмжүүдийг нээх үйл явц, тэдгээрт тодорхой функциональ шинж чанар олгох явдал юм. Эндээс үзвэл уран сайхны соёл нь бие хүний

оюуны үйл ажиллагаатай холбоотой нийгэм-соёлын өвөрмөц давхраа болно.

Уран сайхны соёл нь нийгмийн оюун санааны соёлын нэгээхэн хэсэг юм. Энэ ойлголтыг өргөн ба явцуу утгаар авч үзэж болно. Өргөн утгаар уран сайхны соёл гэдэг нь урлагийн бүтээлд хэрэгжин биелэх болон хүний ухамсарт үйлчлэн нөлөөлөх үнэлэмжүүдийн нийлбэр цогц, тэрчлэн эдгээр үнэлэмжийг бие хүн хүртэх ба эзэмших чанарын түвшин юм. Явцуу утгаар зөвхөн бие хүнд хамаарах уран сайхны таашаал, мэдлэг, туршлага, арга барил, авъяас чадвар, хэрэгцээ, сонирхол зэрэг юм.

Уран сайхны соёлын бүтэц нь урлагийн бүтээлийг үйлдвэрлэх, хадгалах, дэлгэрүүлэх болон хэрэглэх үйл явцтай холбоотой юм. Энэ үйл явцад тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэгч нийгмийн субъект, түүний үйл ажиллагаа, урлагийн бүтээлүүд, бас нийгэм - соёлын институтууд оролцдог. Уран бүтээлч нь субъект болохын хувьд уран бүтээлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ба урлагийн аль нэгэн бүтээлийг бүтээдэг. Харин үзэгч, сонсогч, уншигч, хэрэглэгчид нийгмийн субъект болохын хувьд нийгэм-соёлын аль нэг институтийн хүрээнд уран сайхны үнэлэмжийг хэрэглэх, ашиглах үйл ажиллагаанд орно. Үйлдвэрлэл болон хэрэглээний хоорондох холбогч үйл ажиллагааг өмнө нь бүтээж бий болгосон буюу тухайн үед хэрэгжүүлж байгаа (дуулж, хөгжимдөж гэх мэтээр) уран сайхны үнэлэмжийг дэлгэрүүлж (үзвэр, тоглолт, сургалт, сурталчилгаа зэргээр), хуваарилаж, олшруулан хувилах замаар нийгэм-соёлын институтэд ажиллаж байгаа хүмүүс хэрэгжүүлнэ.

Уран сайхны соёлын тухай ярихад уран бүтээлийн чанар, олон түмэн түүнийг хүртэж буй байдал болон үйлчилгээний чанар зэргийг анхаарах нь чухал байдаг. Урлагийн бүтээлийн чанар нь уран бүтээлч субъектын шинжүүд, түүний уг чанар, хүч, хүнийх нь онцлогоос их хамаардаг. Чанарын үнэлгээний хувьд гэвэл бэлтгэгдэж боловсорсон байдлын түвшин, шалгуураар ялгагдах мэргэжилтэн болон олон түмнээс яг адилхан бодол санаа төрөхгүй нь лавтай. Олон түмний хүртэхүй дийлэнхдээ ердийн ухамсраар тодорхойлогдож, агуулга-утгын талыг нь голлон үнэлж, уран сайхны үнэлэмж талыг нь төдийлөн эрхэмлэдэггүй байна. Уран сайхны хүртэхүй нь насны болон боловсролын онцлогтой, тэрчлэн бие хүний оюуны ерөнхий чадавхитай холбоотой юм.

Оюуны чадавхи гэдэг бол бүтээх, танин мэдэх, үнэлэх, харилцах авъяас чадвар бөгөөд үйлдвэрлэл болоод нийгмийн, гэр бүл болоод чөлөөт цагийн, эсвэл өөр ямар нэг үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх бололцоо юм. Эдгээр чадавхи бүхий авъяас чадвар, бололцоонууд нь уран сайхны үйл ажиллагааны амжилтыг ч тодорхойлно. Бие хүний оюуны чадавхи хэдий чинээ өндөр байна, уран сайхны таашаал төдийн чинээ өндөр түвшинд байх юм. Урлаг нь уран сайхны таашаалыг хөгжүүлж, бие хүний оюуны чадавхид нөлөө үзүүлнэ, оюуны ертөнцийг төлөвшүүлж, энэ маягаар хүний

нийгмийн практик, түүний нийгэм-соёлын чиг баримжааллыг улам төгөлдөржүүлэхэд нөлөөлнө.

Зарим ном бүтээлийг /9. 215, 4. 82-83/ үзвэл ойролцоо санаанууд томъёологдсон байгаа нь илэрхий байна. Тухайлбал: Уран сайхны соёлд холбогдон оролцогч хэсгүүд (компонент)-д:

-Урлагийн бүтээлийг бүтээх ба хүртэх нийгмийн субъект (биехүн, бүлэг, анги, нийгэм)-ийн шинжүүд (мэдлэг, туршлага, дадал дүй, чадвар, хэрэгцээ, сонирхол);

-Уран сайхны үнэлэмжийг бүтээх, хадгалах, дэлгэрүүлэх, хэрэглэх, тэдгээрийг судлах, мөн бие хүнийг хөгжүүлэх зорилгоор эдгээр үйл явцад үйлчлэн нөлөөлөх субъектийн үйл ажиллагаа;

-Үнэлэмжийг тээгч болох урлагийн бүтээлүүд, хүрээлэн буй орчны уран сайхны элементүүд;

-Үнэлэмжийг бүтээх, хадгалах, дэлгэрүүлэх, хэрэглэх, тэдгээрийг судлах, харгалзах нөхцлийг бүрдүүлснээр тэдэнд үйлчлэн нөлөөлөх явдлыг хангах нийгэм-соёлын институтууд (бүтээлч холбоод болон зохион байгуулалтууд, соёл болон урлагийн байгууллагууд, эрдэм судалгааны байгууллага, сургуулиуд, дугуйлан болон студиуд, удирдах байгууллагын бүтэц) зэргийг оруулсан байна.

Эдгээр дөрвөн хэсэг нь уран сайхны соёл үүсэн буй болж, оршин тогтнох, хөгжин цэцэглэх, хүмүүн болоод нийгмийн амьдралд үйлчлэн нөлөөлөхөд зайлшгүй оролцох бүрэлдэхүүн хэсэг болно. Ялангуяа субъектийн шинжүүд энд гол учир холбогдолтой байгаа нь анзаарагдам байгаа бизээ. Үнэлэмжийг тээгч болохынх нь хувьд урлагийн бүтээлүүдийг бүтээх, хадгалах, дэлгэрүүлэх, хэрэглэх, судлах субъектийн үйл ажиллагаа уран сайхны соёлд оролцох нэг чухал бүрдүүлэгч хэсэг юм. Нөгөө талаар уран сайхны соёлыг бүрэлдүүлэгч хэсгүүдийн талаарх дээр дурьдсан баримтлалыг авч үзэхдээ бид зарим санаануудыг дэвшүүлэх оролдлого хийлээ. Юуны түрүүнд уран сайхны соёлыг бүрдүүлэгч хэсгүүд нь өөр хоорондоо нягт харилцаа холбоотой гэдгийг дурьдах нь зүйтэй (Бүдүүвч 1). Гэвч тэдгээрийг уран сайхны соёлыг бүрдүүлэгч хэсгүүд гэж бүрэн дүүрэн зөвшөөрөхөд төвөгтэй байна. Учир юун гэвэл урлагийн бүтээлүүд нь уран сайхны соёлын бүтээгдэхүүн болох бөгөөд харин институтүүд (Бүдүүвч 2-ыг үз) нь уран сайхны үйл ажиллагааны нөхцөл, орчин юм. Бид уран сайхны соёлд холбогдох, түүний бүрэлдэхүүнд оролцох хэсгүүдийг бүдүүвч 2-т латин цагаан толгойн ABCD үсгүүдээр тэмдэглэсэн ба тэгэхлээр D нөхцөлд нийгмийн субъектийн А чадварын ачаар В үйл ажиллагаа явуулж С бүтээгдэхүүнийг буй болгодог байна гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл уран

Бүдүүвч 1

Уран сайхны соёлд холбогдох элементүүдийн харилцаа шүтэлцээ



Бүдүүвч 2

Уран сайхны соёлыг бүрдүүлэгч хэсгүүд / компонентууд

А. Урлагийн бүтээлийг / уран сайхны үнэлэмжийг бүтээх ба хүртэх нийгмийн субъект (биехүн, бүлэг, анги, нийгэм) -ийн шинжүүд / чадвар (мэдлэг, туршлага, дадал дүй, ур чадвар, хэрэгцээ, сонирхол)	С. Уран сайхны соёлын бүтээгдэхүүн: -Үнэлэмжийг тээгч болох урлагийн бүтээлүүд; -Хүрээлэн буй орчны уран сайхны элементүүд.
В. Нийгмийн субъектийн үйл ажиллагаа: -Уран сайхны үнэлэмжийг бүтээх, хадгалах, дэлгэрүүлэх, хэрэглэх; -Уран сайхны үнэлэмж (уран сайхны шүүмжлэл, соёлын тухай шинжлэх ухаан)-ийг бүтээх, хадгалах, дэлгэрүүлэх, хэрэглэх үйл явцыг судлах ; -Уран сайхны үнэлэмж (удирдлага, маркетинг, гоо сайхны хүмүүжил)-ийг бүтээх, хадгалах, дэлгэрүүлэх,хэрэглэх үйл явцад зориуд үйлчлэн нөлөөлөх.	Д. Уран сайхны үнэлэмжийг бүтээх, хадгалах, дэлгэрүүлэх, эзэмших үйл явцыг хангах, тэрчлэн эдгээр үйл явцыг судлах болон зориуд үйлчлэн нөлөөлөх институтууд: -Бүтээлч холбоод болон зохион байгуулалтууд, соёл болон урлагийн байгууллагууд; -Уран сайхны студиуд болон дугуйлангууд; -Соёл болон урлагийн эрдэм шинжилгээний байгууллагууд, сургуулиуд; -Соёлын удирдлагын байгууллагууд.

сайхны соёл бол “уран сайхны” гэсэн тодотголтой соёлын нэгэн хэсэг бөгөөд түүний үр дүн нь уран бүтээл, уран сайхны үйл

ажиллагааны бүтээгдэхүүн юм. Эдгээр нь өөр хоорондоо салшгүй холбоо шүтэлцээтэй боловч нэгийг нь нөгөөд нь багтааж, бүрэлдэхүүнд нь оруулж, түүний "элемент" болгон ойлгож боломгүй байна. Урлаг бол зүгээр л дуу авиа, хэлбэр дүрс, өнгө будгийн зохистой хослол лүгээ адил зүйл бол, харин уран сайхны соёл нь тэдгээрт амь оруулж, хүний дотоод ертөнцийг доргиож, нулимасыг нь мэлмэрүүлж, "хайлуулж" самсайг нь сартайлгаж, ямар нэг "өөр ертөнцөд" аваачиж, "умбуулж", баясгаж байдаг увидастай юм. Уран сайхны соёл гээч "соёл" мөнхийхөө ид шидийг үзүүлж байгаа нь тэр л дээ. Гэхдээ урлагийг эфирт цацагдаад алга болчихдог, эсвэл хуучирч муудаад устчихдаг "үхмэл" зүйл гэж үзэж хэрхэвч болохгүй. Яагаад гэвэл түүнд шингэсэн "соёлын увидас" буюу түүнийг бүтээсэн санаа, үзэл баримтлал, үнэлэмж, мэдлэг, бишрэл, заншил, бэлгэдэл, зан үйл, уламжлал, ур чадвар, дэг жаяг, хэм хэмжээ, эрхэмнэл зэрэг нь хүний сэтгэлийг гэгэлзүүлж, үеэс үед дамжин уламжлагдаж, дурсагдаж байдаг онцлогтой юм. Чухам иймээс уран сайхны үйл ажиллагааны үр нөлөө нь тухайн субъектийн соёлын түвшнээс л хамаарна гэж үзэх бүрэн үндэстэй юм.

3. Урлагийн талаар

Хоруженкогийн толинд /14. 182/ урлагийг: а/.Бүхэлдээ уран сайхны бүтээл буюу уран зохиол, уран барилга, баримал, уран зураг, зураасан зураг, чимэглэлийн-хавсрага урлаг, хөгжим, бүжиг, театр, кино болон бодит байдлыг тусгах уран сайхан-дүрийн хэлбэрээр нэгтгэсэн хүний үйл ажиллагааны бусад олон янз байдал юм; б/.Явцуу утгаар дүрслэх урлаг; в/.Үйл ажиллагааны алив хүрээн дэх ур чадварын өндөр зэрэг юм гэж тэмдэглэсэн бол Радугиний редакцитай гарсан соёл судлалын нэвтэрхий толинд "Урлаг нь ертөнцийг уран сайхны хувьд танин мэдэж, эзэмшихэд чиглэсэн хүмүүсийн оюуны практик үйл ажиллагааны хүрээ юм. Урлаг нь хүний мэдрэхүй чанарын хөгжингүй хэлбэрүүдэд хүрээлэн буй бодит байдлыг дахин босгож бүтээх, хүний универсаль хэрэгцээг хангахад чиглэгдэнэ." Мөн "Хамгийн өргөн утгаар "урлаг" хэмээх ойлголт нь хүмүүсийн уран чадвар, чадамж, ховорхон дадал дүйтэй адилтгагддаг" /17. 164/ гэжээ. Философийн нэвтэрхий тольд "Урлаг нь нийгмийн ухамсрын нэг хэлбэр, ертөнцийг практик, оюунаар эзэмших онцгой төрөл"... "Өргөн утгаар урлаг нь уран сайхны ба уран сайхны бус аливаа үйл ажиллагааны салбар дахь ур чадварын дээд түвшинг, өөрөөр хэлбэл тухайн ажлын төгс төгөлдөр гүйцэтгэлийг тэмдэглэж, тэгснээрээ гоо сайхны утга санааг шууд олж авдаг. Яагаад гэвэл гойд үйл ажиллагаа хаа нэгэн газар, ямар нэгэн байдлаар илрэхгүй байсан ч сайхан, гоосайхны учир холбогдолтой байдаг" /13. 222/, Санкт-Петербургт 1997 онд хэвлэгдсэн "Соёл судлал. XX зуун. Толь"-д "Урлаг нь амьдралын ертөнцийг гоо сайхны хувьд эзэмших, бүтээлч ургуулан бодохуйн нөөц дээр

тулгуурласан дүр-бэлэгдлийн түлхүүрээр түүнийг дахин босгох субъектийн авъяас чадвартай холбоотой соёлын хэлбэр юм" /7. 159/ гэж тус тус томъёолсон байна. Дээрх тодорхойлолтуудаас үзвэл "урлаг", "уран сайхны соёл" хоёрыг ихэд хольсон байдал харагдах бөгөөд урлагийн тухай өргөн утга гэсэн хэсэг нь "урлаг"-т бус, харин "уран сайхны соёл"-д илүү дөхүүтэй ойлгогдож байгааг зориуд тэмдэглэе. Гэхдээ энэ нь урлагийг соёлтой адилтгах үндэслэл огтхон ч биш гэдгийг хэлмээр байна.

Урлагийн тухай олон тодорхойлолт байдаг. Энэ үзэгдлийг ойлгох үндсэн хандлагуудыг аваад үзье:

1. Юуны түрүүнд, урлаг нь бодит байдлыг тусгах хийгээд эзэмших онцгой төрөл юм. Олон жилийн турш түүнийг урлаг судлаачид судлаж, улмаар цааш нь "сайхны хуулиар хүрээлэн буй ертөнц болон өөрийгөө бүтээлчээр өөрчлөх хүний авъяас чадварыг буй болгож, хөгжүүлэх зорилготой..." гэсэн тодотголыг нэмсэн байна. Гэтэл урлагт зорилго оршин байх баримт өөрөө маргаантай бөгөөд сайхны тухай ойлголт харьцангуй, яагаад гэвэл сайхны эталон янз бүрийн соёлын уламжлалд (тухайлбал, өрнө ба дорнын соёлд) хүчтэй ялгагдаж, муухайн илрэлээр дамжиж илрэх (И.Босх, А.Дюрер, модернизм ба постмодернизм), бас бүр үгүйсгэгдэх(абсурд урлаг) байдлаар нотлогдож болно гэдгийг анзаарах нь зүйтэй юм.

2. Нөгөө талаар, урлаг нь уран сайхан-гоо зүйн үнэлэмжүүдийг хуримтлуулах соёлын нэг элемент болно.

3. Бас нэг зүйл бол урлаг нь ертөнцийг мэдэрч танин мэдэх хэлбэр юм. Хүний танин мэдэхүйд рациональ (сэтгэхүйд үндэслэсэн логик, хийсвэр), мэдрэхүйн (мэдрэмж, сэтгэл хөдлөлд үндэслэсэн), иррациональ(зөн совинд үндэслэсэн) гэсэн гурван аргыг ялган үзэж болно. Хүний оюуны соёлын үйл ажиллагааны үндсэн илрэлүүдэд, соёлын бэлгэдлийн төрх царай болсон, нийгмийн учир холбогдол бүхий мэдлэгийн хэсгүүдэд (шинжлэх ухаан, урлаг, шашинд)/ эдгээр нь гурвуулаа байдаг байна, гэхдээ аль нэгэнд нь нэг нь л давамгайлах тал (шинжлэх ухаанд рациональ, урлагт мэдрэхүйн, шашинд зөн совингийн) ажиглагдана.

4. Урлагт хүний бүтээлч авъяас чадварууд илэрдэг (энэ нь уран бүтээлчид холбогдох асуудал болно).

5. Урлагийг хүнд сэтгэл ханамж, цэнгэл баяслыг (урлагийг хүртэх, ойлгох асуудал) авчирдаг уран сайхны үнэлэмжийг хүн эзэмших үйл явц гэж үзэж болно /8. 114/.

Үүнээс үндэслэн урлаг бол соёлын өвөрмөц бөгөөд нилээд бие даасан хэсэг юм. Урлаг нь ертөнцийг гоо зүйн хийгээд оюуны практикийн хувьд эзэмдэх субъектийн авъяас чадвартай холбоотой соёлын хэлбэр, бодит байдлыг уран сайхны дүрээр тусгах нийгмийн ухамсар хийгээд хүний үйл ажиллагааны онцгой тал, объектив бодитой байдлыг гоо сайхнаар ойлгох чухал аргуудын нэг, бүтээлч ургуулан бодохуйн нөөц дээр тулгуурлаж, дүр, бэлгэдлийн замаар түүнийг хуулбарлахуй, хүн өөрийн мөн чанарыг бүрэн нотлож

илэрхийлэх өвөрмөц хэрэгсэл, хүнд “хүний чанарыг” хэвшүүлэх арга гэхчлэн түүнийг олон талаас нь тайлбарласан байдаг.

Гэтэл урлаг бол “дүр” мөн гэдэгт эргэлзээтэй тал бий, харин уран бүтээлч үг, авиа, хөдөлгөөн, өнгө будаг, хэлбэрээр илэрхийлсэн бөгөөд түүний ухамсарт хэлбэрээ олсон ертөнц болон хүний тухай “уран сайхны дүр”, бүхэлдээ уран сайхны бүтээл болно. Хүмүүсийн хоорондох харилцааны хүчирхэг хэрэгсэл болох, мэдрэмж, сэтгэл хөдлөлтэй холбоотой байх, бодит байдлыг ялангуяа мэдэрч хүртэхүй, гарцаагүй субъектив хүртэхүй болдог, дүрслэх хийгээд бүтээлч шинж чанар зуршмал байх зэрэг нь урлагийн ялгагдах гол шинжүүд юм.

Эдгээрээс харахад урлагийн олон янзын утга байх бөгөөд бид урлагийг уран сайхны үйл ажиллагааны үр дүн, бүтээгдэхүүн гэдэг утгыг нь илүү дэмжиж байгаа болно. Урлаг нь уран сайханы соёлын гол зорилго бөгөөд нэг талаас уран бүтээлийн бүтээгдэхүүн, нөгөө талаас хүн, нийгмийн хуримтлуулсан үнэлэмжүүдийн нийлбэр цогц юм. В.В.Селивановын илэрхийлснээр энэ нь уран сайхны соёлын юмс-бодослог фонд юм /15. 15/. Жишээ нь: зураачдын зурсан болон музейд хадаглагдаж байгаа зураг, нотны тэмдгүүдээр тэмдэглэгдсэн болон хураамж түүвэр зэрэгт хэвлэгдсэн хөгжим, ном, товхимол хэлбэртэй уран зохиолын бүтээл гэх мэт юм. Гэхдээ уран бүтээлийн бүтээгдэхүүн үйл ажилгааны баримтын хэлбэрээр байж болно (хөгжим тоглох, дуу дуулах гэх мэт). Урлагийн зүйлийг бүтээх, бүтээлийг тоглох нь харин уран сайхны соёлын тогтолцоонд орох гоо сайхны үйл ажилалгаа, уран сайхны бүтээлийн үйл явц юм.

Социологийн үзэгдлийн үүднээс урлагыг хүний ухамсарт үйлчлэн нөлөөлөх үзэл санаа, үзэл бодол, утга санаа, үзэл баримтлуудын нийлбэр цогц болох нийгмээс хуримтлагдсан уран сайхны үнэлэмжүүд гэж үзэж болно. Энэ утгаараа урлаг нь зөвхөн уран сайхны соёлтой төстэй төдийгүй, нийгмийн оюуны соёлтой нэн холбоотой юм.

Ном зүй:

1. Всемирная энциклопедия: Философия. – М.:АСТ, Мн.:Харвест, Современный литератор, 2001. -1321с.
2. Гуревич П.С. Философия культуры. Учебник для высшей школы. – М.:Издательский дом NOTA BENE, 2001. -352с.
3. Т.Дорждагва, Н.Сарантуяа, Ж.Долгорсүрэн. Соёл судлалын үндэс. УБ.:Урлах эрдэм, 1998.
4. Дуков Е.В. и др. Введение в социологию искусства: Учебное пособие для гуманитарных вузов. -СПб.: Алетеия, 2001. - 256с.
5. Журавлев В.В. Мир художественной культуры. –М.:Мысль, 1987.
6. Kroeber A.L., Kluchohn C. Culture. A Critical Review of Concepts and Definisions. - Cambridge-Massachusetts, 1952.
7. Культурология. XX век. Словарь. – Санкт-Петербург: Университетская книга, 1997. –640с.
8. Культурология: Учебник для студентов вузов / Колл.авт.:Под ред. Н.Г.Богдасарьян. – 3-е изд., испр. и доп. – М.: Высш.шк., 2001. – 511с.

9. Михайлова Л.И. Социология культуры: Учебное пособие.-М.: ФАИР-ПРЕСС, 1999. -232с.
10. Полищук В.И. Культурология: Учебное пособие. -М.:Гардарики, 1999. -446с.
11. Полищук В.И. Мировая и отечественная культура. -Екатеринбург, 1993.-Ч.1.
12. Философский словарь. Под редакцией И.Т.Фролова. Издание четвертое. - М., 1980.
13. Философский энциклопедический словарь. -М.:Советская энциклопедия, 1983.
14. Хоруженко К.М. Культурология.Энциклопедический словарь.-Ростов-на-Дону: Изд-во "Феникс", 1997. -640с.
15. Художественная культура и искусство: Сб. науч. тр. / Отв. ред. В.Е.Гусев. - Л.:ЛГИТМИК, 1987.
16. Цэдэндагвын Гомбосүрэн. Нийгмийн философид интеграль ойлголтууд боловсруулах онол, арга зүйн асуудлууд. Диссертаци. Эрдэм шинжилгээний зөвлөх академич С.Норовсамбуу. УБ., 1997.
17. Энциклопедический словарь по культурологии. /Под Общ. редакцией А.А.Радугина. - М.: "Центр", 1997. -480с.